

Дээрх саналуудыг хэрэгжүүлснээр хилчин офицерууд улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагын талаарх онолын мэдлэгтэй болж, энэ нь холбогдох бодлого, хууль эрх зүйн хүрээнд практик ажиллагаанд хэрэгжинэ. Ингэснээр улсын хил хамгаалалт нь шинжлэх ухааны үндэстэй явагдана гэж үзэж байна.

*Ш.Далайбаатар- ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын акадамын 8042 дугаар*

*дамжааны суралцагч, хошууч
В.Пүрэвбаасан-Хууль сахиулахын удирдлагын
акадамын Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа*

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙАСУУДАЛ

Хураангуй: Хилийн аюулгүй байдал нь тодорхой орон зай /хилийн орон зай/ дахь үндэсний ашиг сонирхлын аюулгүй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгүй байдлын бусад бүрэлдэхүүнд шууд нөлөөлж байдаг. Иймээс хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орон зайд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг эх сурвалж, цаг хугацаа, шинж чанар, учруулах магадлаар нь дотоод, гадаад гэж хуваан үзэж болох ба хилийн орон зайд төр, нийгэм, иргэний амин чухал эрх ашигт аюул учруулж байгаа нөхцөл болон хүчин зүйлүүдийн нийлбэр цогц юм.

Түлхүүр үг: Монгол улс, төр, бодлого, хил, хилийн аюулгүй байдал, хилийн зурвас, бүс.

Оршил

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”¹ гэж Үндсэн хуульд зааснаар, зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтний түүхийн

¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл №28/963. УБ., 2001.

тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг таслаж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ¹.

Энэ нь Хүн ам цөөн. газар нутаг өргөн уудам. нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна. 70 гаруй жилийн өмнө Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр, дээрмийн аргаар эзэмшихийн төлөө явагдсаныг бид мартаагүй байна.

Өнөө үед хил, хязгаарт амьдардаг хүн амын ихэнх нь төврүүгээ нүүдэллэж олонх нь хот суурин газар амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна. Энэ нь улс орны эдийн засгийн байдал, экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрснөөр олон улсын эрх зүйн үндэс бүрдсэн байна. Цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажсан хилийг өөрчлөхгүй, зөрчилгүй, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг болж байна.

Улсын хилийг хамгаалах талаар хууль эрх зүйн орчин бүрдэж, Монгол удсын хилийн тухай хуульд бүлэгчилэн тодорхой тусгаж өгсөнөөр хилийн аюулгүй байдлын талаар баримтлах эрх зүйн үндэслэлтэй болсон.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд

¹ Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”.УБ.,2004. 38. дахь тал.

хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна¹. гэж тэмдэглэсэн байна.

Хилийн аюулгүй байдал

Хилийн аюулгүй байдал гэдэг нь “улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал”² гэж манай эрдэмтэд үздэг билээ.

Аюулгүй байдал

1 "Аюулгүй зовлон гачаалгүй байх" ПЛАТОН	1 г" "Аюулгүй бүрэн бүтэн байх, итгэл найдвартай байх" В.Даль		'.....\ "Бодит аюулгүйн үр дүнд бий болох амар тайван нөхцөл байдал" (бие мах бодийн болон сэтгэл санааны аль аль нь) Зоненфельс
	i >		

Үндсэн хэсэг: Судлаач миний бие хил, хязгаарыг тайлбарласан нэр томъёог хурандаа Д.Дашдаваа багшийн түүвэрлэн тайлбарласан хэсгээс иш татсан болно. Хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, өөрийн гэсэн нэр томъёотой. Жишээ нь:

Нутгийн зах: Тухайн нутаг дэвсгэр, аливаа бэлчээрийн хязгаарыг тодорхой уул, овоо, гол мөрнөөр багцаалан нэрийдэх.

Нутгийн дээс: Нутгийн захыг газар дээр нь тогтоосон шугам, тодотгол. Нутгийн захыг тодорхой хэмжээс бүхий дээсээр хэмжиж тодорхойлж байснаас үүдэлтэй нэр томъёо.

Нутгийн овоо: Нутгийн захыг овоо босгон тэмдэглэх заншлаас улбаатай нэр томъёо. Ихэвчлэн чулуу, модон овоо байсан. Модонд бичиг сийлж голд нь хатгах, нутаг нийлэх талууд модонд бичиг бичиж олонд мэдэгдэлгүйгээр булж нуух зэргээр баталгаажуулж байсан хилийн тэмдэг.

Нутгийн зааг: Монголын нутаг дэвсгэрийн заагийн зургийг анхлан манай эриний 46 онд үйлдсэн сурвалж бий. Газрын зургийг даавуу, торго, арьс зэрэг дээр зурдаг байсан.^{1 2}

¹ Монгол улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл №06/963”. УБ., 2017.

² Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”. УБ., 2004. 38. дахь тал.

Нутгийн цэс: Аливаа эзэмшлийн, өөрөөр хэлбэл хошуудын газар нутгийн хэмжээ, дотоод хуваарь, захын овоодын хоорондох зай, зүг чиг, дугаар. аль талаараа ямар нутагтай зах нийлэх зэргийг нарийвчлан бичсэн тэмдэглэл.

Хилийн цэс: Одоогийн орон нутгийн засаг захиргааны нэгж нийслэл, аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн захыг тогтоосон нэр томъёо.

Хүн төрөлхтний гүүхэнд улсын хилийн асуудлаар улс гүрний хаад, төр засаглагч, эрдэмтэн мэргэд онолын үзэл баримтлалуудыг номлож, энэ нь соёл иргэншил, дайн ба энхийн асуудлаас шууд хамааралтайгаар хүний нийгмийн түүхэн үйл явцад төр улс орших, эс оршихуйг тодорхойлогч гол хүчин зүйл нь хилийн аюулгүй байдал байсаар л ирсэн¹. Дээрх тайлбаруудаас харахад хил гэдэг үгийг газар нутгийн зах хязгаарыг заагласан шугам, түүний орчим газрыг илэрхийлсэн утгаар тайлбарласан байна.

“Аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар толь: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй”, “аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх”^{1 2} гэж тайлбарласан.

“Хилийн аюулгүй байдал” гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт улс, нийгэм, иргэдийн язгуур эрх ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ³.

Монгол Улсын оршин тогтнохуйн бүхий л хугацаанд хил хязгаар гэсэн ухагдахуун төрийн бодлогын байнгын анхааралд байж, түүний хамгаалалт нь ямагт улс төр, дипломатын, цэргийн дэглэмийн арга хэмжээгээр голлон хэрэгжиж ирсэн болно. 1962 оноос хойд хилд, 1979 оноос хилийн шугамын хамгаалалт дагнасан байдалтай байгаад 2002 онд Монгол Улсын Их Хурлын тогтоолоор Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого⁴ батлагдан гарч хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын шинэ үе эхэлсэн гэж хэлж болхоор байна.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм⁵.

¹ Дашдаваа Д. “Улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал”. УБ., 2014. 20 дахь тал

² Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966. 60 дахь тал

³ Монгол улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл №06/963” 5-2т. УБ., 2017 Арвай Ш. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015. 9 дахь тал.

⁵ Арвай Ш. “Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол”. УБ. 2005. 35 дахь тал.

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”¹ гэж Үндсэн хуульд зааснаар. зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш. нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичигт “Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ”^{1 2 3} гэж заасан. Энэ нь хилийн аюулгүй байдлыг агуулгын хувьд бүрэн хамарч чадаагүй байна.

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын төрийн, орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагууд хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх мэдлийн хүрээнд улс төр, эрх зүйн, дипломатын, батлан хамгаалах, цэргийн, тагнуулын, оператив-эрлийн, гаалийн, экологийн, хүн-мал эмнэлгийн ба бусад арга хэмжээг нэгдмэл бодлоготой, харилцан уялдаатай явуулах зэрэг үйл ажиллагаагаар хангагдана’ гэж зассан нь хилийн аюулгүй байдлын ерөнхий ойлголт, хангах арга зам, чиглэл нь тодорхойлогдож байгаа юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол асуудал нь хилийн орчинд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход гол зүйл юм.

Товчоор хэлэхэд хилийн аюулгүй байдал нь зөвхөн гадны улсын түрэмгийллээс улс орны хил хязгаарыг хамгаалах бус олон улсын алан хядагчид, хууль бусаар цагаачлагчид, хар тамхи, хүнийг хууль бусаар хил нэвтрүүлэх, бусад үндэстэн дамнасан гэмт хэрэгтнүүд тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэхээс сэргийлэх зэрэг илүү өргөн утгыг илэрхийлдэг. Судалгаанаас үзэхэд:

Дийлэнх хөгжсөн орнууд улсын хилээ дараах гурван шалтгаанаар хамгаалдаг байна. Үүнд:

1. Дотоодын хуулийн дагуу үл хүсэх гадаадын иргэдийг (гэмт хэрэгтнүүд, хар тамхины наймаачид, алан хядагчид гэх мэт) тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэхээс сэргийлэх;

¹ Монгол Улсын үндсэн хууль. Цахим эх сурвалж, холбоос. Legalinto.mn

² Арвай Ш. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015.15 дах тал.

³ Төртөгтох Т. “Улсын хилийн аюулгүй байдал”. УБ.. 2004. 54 дэх тал.

2. Татвар хураамж авах. гаалийн хууль тогтоомж зөрчигчдийг илрүүлэх, шийтгэх, хууль бус барааг хураах;

3. Хортой, эрүүл бус. эрүүл ахуйн шаардлага хангахгүй жимс, ногоо, ургамал, амьтнаас халдварт өвчин дэлгэрэхээс сэргийлэх' зэрэг шалтгаанууд орно. Үүнээс үзэхэд хилийн аюулгүй байдал гэдэг нь хөгжсөн орнуудын хувьд хууль бусаар хүн хил нэвтрэх явдлыг таслан зогсоох, гаалийн хяналт шалгалтыг явуулах, эрүүл ахуй, мал эмнэлэгийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байдаг гэдэг нь харагдаж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хамгаалах, гадаад, дотоодын аюул, заналаас төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ, хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, хөрш улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, арилгах тогтолцоо бүрдүүлэхэд оршиж байна.

Үүнээс үзэхэд хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилт нь:

Газар нутгийн бүрэн бүтэн байдал;

- Улсын тусгаар тогтнолыг хангах

Улсын хил, хязгаар нутаг, сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийн зөрчилгүй байлгах болон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах

- Хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчүүлэхгүй байх

Хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал гэж үзэж болох юм.

Бүс нутгийн аюулгүй байдал хилийн аюулгүй байдалд

нөлөөлөх нь

Улсын хил хамгаалалт нь Үндэсний аюулгүй байдал ба Батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн.

Үндэсний аюулгүй байдал гэдэг нь: Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал нийгэм төрийн байгууллагын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, шинжлэх ухаан технологийн аюулгүй байдал мэдээлэлийн аюулгүй байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам удмын сангийн аюулгүй байдал, экологийн аюулгүй байдал юм.

Батлан хамгаалах арга хэмжээ гэдэг нь: Батлан хамгаалах нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээ юм.

Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, түүнийг хангахад Монгол Улсын хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг болох улсын хил хамгаалалт онцгой чухал үүрэгтэй.

' Дашдаваа Д. "Улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал". УБ., 2014. 25 дахь тал

Бүс нутаг ба аюулгүй байдал:

Бүс нутгийг дээр дурьдсан чиглэлүүдээр нь тодорхойлон хэлж болох бөгөөд цэргийн шинжлэх ухаанд суурылан дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чиглүүлэн бүс нутаг ба аюулгүй байдал талаас нь дэлхийн улс гүрнүүд аюулгүй байдлаа хангах үндэсний бодлого стратегийг бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч, ингэхдээ дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлыг чухалчлан үзэж байна.

Цэргийн эрдэмтэд, онолчид ертөнцийн орон зайг геостратегийн орон зайгаар нь дараахь бүсүүдэд хуваан авч үзэж байна.

Үүнд : - Тивийн бүс;

- Эх газрын бүс;
- Далайн бүс;
- Стратегийн орон зайн бүс;
- Сансрын бүс гэх мэт.

Эдгээрээс стратегийн бүсийг: тив дэлхийн газар нутгийн хэсэг эсвэл тухайн газар нутгийг бүхэлд нь ойролцоо байх эдийн засгийн бүс, агаарын орон зайг хамтатган авч үзэж аливаа улсын цэрэг эдийн засгийн болзошгүй аюулаас хамгаалах орчин юм гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын хувьд бүс, бүс нутаг, стратегийн болон оперативын орон зайгаа тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд өнөөдрийн байдлаар төв болон дундад, зүүн хойд, зүүн өмнөд Ази, Европын Орос дахь газар нутаг, Казакстан, Хятадын газар нутаг бүхэлдээ, Энэтхэгийн болон Номхон далайн хэсэг болон Солонгосыг багтаасан орон зайг өөрийн улсын аюулгүй байдлын бүс, бүс нутаг гэж авч үзэж болох юм.

Өнөөдөр дэлхийн газар нутаг үндсэндээ их гүрнүүдийн хяналтад хуваагдаж, тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх аливаа сөрөг хүчин зүйлийг даван туулах, арилгахад чиглэсэн цэрэг-улс төр, худалдаа-эдийн засаг болон бусад бодлого, үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа нь нэгэнт тодорхой билээ.

Уламжлалт их гүрнүүд болон хүн ам, газар нутаг, хөгжлөөрөө тэргүүлэгч улсууд дэлхий дахинд өөр өөрсдийн бодлого /улс төр, эдийн засаг, хууль, худалдаа, далай тэнгисийн баялаг, ашигт малтмал, газрын тосны нөөц гэх мэт хөгжилд түлхэц өгөхүйц эх сурвалжуудыг эзэмших, ашиглах. хяналтадаа байлгах/-ыг тодорхойлон өрсөлдөж байгаа нь нууц биш бөгөөд энэхүү сөргөлдөөн тэмцлийн явцад тухайн бүс нутагт оршиж байгаа бага, дунд буурай улс орнуудын язгуур эрх ашиг, аюулгүй байдал хөндөгдөж, эдгээр эрх

¹ Наранжамц.Н "Бүс нутаг-хил хамгаалалтын талаарх үзэл баримтлал".УБ., 2012 он. 13 дахь тал.

ашиг нь хөндөгдөж буй улс орнууд оршин байх, аюулгүй байдлаа хангахад онцгой анхаарах боллоо.

Өөрөөр хэлбэл тухайн улсын аюулгүй байдал нь бүс нутгийн аюулгүй байдал болон дэлхий дахин, бүс нутгийн глобал хямрал /дэлхийн дулаарал, эдийн засгийн хямрал, байгаль-экологийн сүйрэл, нөөцийн хомсдол гэх мэт/-аас шууд ба шууд бус хамааралтай болох нь нэгэнт тодорхой болж байна.¹

Монгол улс хэдийгээр далайд гарцгүй, эх газрын улс боловч дэлхий дахин болон бүс нутагт нөлөө бүхий хүчирхэг их гүрнүүдтэй хил залган оршдог, аюулгүй байдал нь дээр дурдсан улс орнуудаас шууд хамааралтай төдийгүй бүс нутагт дээрх улсуудын нөлөөгөөр тогтвортой байх, тогтворгүй байх нь шууд шалтгаалах эмзэг орчинд оршин тогтнож байна.

Дэлхий дахинд цэрэг улс төрийн нөхцөл байдал төдийлөн таатай бус, бүс нутаг, улс хоорондын зөрчил тэмцэл үргэлжлэн, зарим тохиолдолд бүхэл бүтэн тив, улсыг хамарсан /хувьсгал/ тэмцэл гарч, дээрх бүс нутаг, улс оронд тогтворгүй байдлыг бий болгож, улмаар дэлхий дахины цэрэг, улс төр, нийгэм эдийн засагт нөлөөлөхүйцээр даамжирах хандлага бий болж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарах, эдийн засаг, хүмүүнлэгийн хямрал нүүрлэх, улмаар хөрш орнуудын дотоод улс төрийн байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс их биш ч, үгүйсгэж боломгүй хэмжээнд байна. Үйл явцын ийм таагүй өрнөлийн үед зэвсэгт бүлэглэлүүд салан тусгаарлагчид, олон улсын террористууд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа идэвхжиж болзошгүй юм.

Нөгөө талаар Монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг үгүйсгэж, улсын хил зөрчин гэмт хэрэг үйлддэг, хил орчмын нутаг дэвсгэрт амьдрагч иргэдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлдэг, улсын хилээр хориглосон бараа материал, зэвсэг галт хэрэгсэл хил нэвтрүүлдэг, зохион байгуулалтгайгаар автомашин, спирт, ноос ноолуур, ангийн үс, эд эрхтэн, архелогийн олдвор, үнэт металл, ховор эдлэлийг хууль бусаар хил нэвтрүүлэн худалддаг гэх мэт уламжлалт зөрчлүүд, сүүлийн үед хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис хил давуулах гэмт хэрэг илэрхий даамжрах хандлагатай болж, бүс нутагт энэ төрлийн гэмт хэрэг идэвхжиж, манай улс дээрх гэмт хэргийн сүлжээнд бүртгэгдэж, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлээс манай иргэдийг болон хилийн хяналт шалгалтын сайнгүй нөхцөл байдлыг гэмт үйлдэлдээ ашиглах боллоо. Түүнчлэн улсынхаа хилийг эцэслэн тодорхойлж, тогтоогоогүйн улмаас хилийн асуудлаарх маргаан нь даамжран

¹ Наранжамц.Н “ Бүс нутаг-хил хамгаалалтын талаарх үзэл баримтлал”. УБ., 2012 он. 13 дахь тал.

бүс нутгийн зарим улсуудын хооронд улс төр, дипломатын аргаар зохицуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болгоход хүргэж байна. Бүс нутагт салан тусгаарлах үзэл, ажиллагаа идэвхжиж, үргэлжилсээр байгаа нь томоохон улсуудын улс төр, цэрэг, эдийн засгийн хүчийг туйлдуулах, залхаахад хүргэж, улмаар салан тусгаарлагчидтай хүчний тэмцэл явуулахад хүргэж байгаа нь дүрвэгсэд, нууцаар хил нэвтрэгсдийн тоог өсгөхөд хүргэж болзошгүй байна.

Бүс нутаг ба улсын хил:

Бүс нутаг дахь таагүй нөхцөл байдал нь тухайн бүс нутаг дахь улс орнуудын аюулгүй байдал, түүний дотор улсын хил, хилийн орон зайд улс үндэстний аюулгүй байдалд нөлөөлөх тодорхой сөрөг хүчин зүйлүүдийг (нөхцөлийг) бий болгодог байна.

Улсын хилийн бүс, хилийн бүс нутаг нь хил хамгаалах байгууллага, түүний анги салбаруудын алба-байлдааны ажиллагаа явуулж байгаа үндсэн нутаг дэвсгэр бөгөөд энэ нутаг дэвсгэр нь хөгжлөөрөө, байгаль цаг агаарын байдлаараа, хилийн цагийн байдлын өрнөлтөөрөө харилцан адилгүй орон зайд оршдог болно.

Дэлхийн улсуудын авч үзэж байгаагаар дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх, зайлшгүй анхаарвал зохих дараах сөрөг хүчин зүйлүүдийг бий болгодог гэж үздэг байна.

Үүнд:

> Хөрш улсуудын тусгай албадын явуулж буй тагнуул-сөрөг ажиллагаа, үл үзэгдэж хил нэвтэрч буй сөрөг урсгал;

> Тухайн улсыг өөрийн геополитикийн ашиг сонирхлын хүрээнээс гаргах зорилгоор бусад бүлэг улсуудын зүгээс тодорхой бүс нутагт өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлэх хүчин чармайлт тавьж буй байдал болон найрсаг дотно харилцагч улсуудтай явуулах хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх оролдлого;

> Хил залгаа улсуудын үндсэрхэг үзэлтэй байгууллагууд өөрийн төр засгаас тухайн улсад алдагдсан болон маргаантай газар нутгаа эргүүлэн авах элдэв шаардлага, шахалт үзүүлэх ;

> Хилийн шугамын явалт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй нутаг дэвсгэрийн харъяаллын талаархи санал зөрөлдөөнийг хурцатгах;

> Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хүндрэл;

> Олон улсын гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар дүрвэгсдийг тухайн оронд оруулах, гуравдагч улсад гаргах болон түүхий эд, үнэт зүйлс.

материалын нөөц, зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого;

> Хил залгаа улстай хилийн шугам тодорхой тогтоогдоогүй байдал. цэрэг улс төрийн цагийн байдлын хурцдал, хил орчим дахь хууль бус бүлэглэлийн үйл ажиллагаа, улс орны дотоод зөрчлийг зохицуулах үйл явцын хүндрэлтэй холбоотойгоор хилийн зарим хэсгийн цагийн байдал тогтворгүйжих;

> Хил хамгаалах байгууллага, хилчдийн эсрэг тухайлбал, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт газруудад гэмт хэрэгтэн, алан хядагчдын зүгээс явуулж буй хууль бус үйл ажиллагаа идэвхжих;

> Мэдээллийн сөргөлдөөний идэвхижил, улс үндэстэн дамнасан гэмт хэрэгийн бүлэглэлүүд төр засгийн эрх мэдлийг бууруулах, хил орчмын оршин суугч, цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд турхирах, заналхийлэх замаар сэтгэлзүй мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж явуулах;

> Улс орны дотоод дахь цэрэг-улс төр, бизнес болон бусад ашиг сонирхолын зөрчлийн улмаас улсын хил хамгаалах байгууллагын зохион байгуулалтад сөрөг нөлөөлөх, хүчийг сулруулахад хүргэх зэрэг болно.

Орчин үед дэлхийн улсуудын олон улсын тавцан дахь байр суурь нь юуны түрүүнд байгалийн баялаг, технологи, мэдээллийн нөөц, тэдгээрийг борлуулах зах зээлийг эзэмших зорилго бүхий өрсөлдөх чадвараар хэмжигдэж байна.

Улсын хил, хилийн аюулгүй байдалд учруулж болох аюул заналыг бүхэлдээд:

- Улс төрийн ;
- Эдийн засгийн;
- Нийгмийн
- Цэргийн;
- Хүн амын;
- Байгаль экологийн аюулгүй байдалтай шууд холбоотой гэж үзэж байгаа бөгөөд улсын хил, хилийн орон зайд улсын хил хамгаалалтын найдвартай тогтолцоо бий болгохыг дээрх нөхцөл байдлууд шаардаж байдаг болно

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголтыг нэгтгэн дүгнэхэд: Хилийн хүрээнд явагддаг бүх харилцаа хамардаг учир түүнийг зөв ойлгож, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт, олон улсын терроризмтай тэмцэх, урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээ нь хилийн аюулгүй байдалд нэн тэргүүнд төлөөлөх асуудал болно гэж дүгнэж байна.

Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам, хил залгаа улсуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог харгалзан хил хязгаарт оршин буй аюулыг олж харах, сэрэмжлэн зайлуулах асуудал асар ач холбогдолтой байна. Ийм учраас зөвхөн хууль сахиулах үүргээ чанартай биелүүлээд зогсохгүй, эх орондоо учирч болох аюулыг урьдчилан мэдэж, тухай бүр түүний эсрэг арга хэмжээ авах нь нэн чухал юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах тодорхой тохиолдол бүрт Хил хамгаалах байгууллагын болон бусад яамд, газрын хүч хэрэгслийг ашиглах үйл ажиллагааны онцгой арга, хэлбэр шаардагдана. Үүний тулд хил хязгаарт бүрэлдэж байгаа нөхцөл байдал, цаашдын хандлагыг нарийвчлан судалж, дүгнэх хэрэгтэй болно.